



History of the XX Century Mongolia

Lecture 3

STATE POLICY TO DEVELOP MONGOLIA LIKE BRITAIN

LECTURER: OTGONJARGAL SODNOMDARJAA
NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

XX зууны Монголын түүх

Лекц 3

*1911 оны хувьсгал: Монгол улсаа Англи лугаа
хөгжүүлэх гэсэн төрийн бодлого*


Проф. Отгонжаргал Содномдаржаа

Монгол Улсын Их Сургууль

Лекцийн агуулга

- Дэлхийн улс гүрнүүдийн үндсэн хуулийн түүх
- Энэхүү үндсэн хуулиудын субстанц юу байсныг мэдэж авах болно.

Улс орнуудын хүн амын тоо




Манж, Хятадаас гадна Орос, Япон, АНУ, Их Британи зэрэг их гүрнүүдийн давхар колончлолын бодлогыг сөрөн Манжийн эрхшээлд байсан Монгол 1911 оны 12 сарын 29-нд Ар Монгол дэлхий дахинд Тусгаар тогтнолоо тунхаглав.

Эх үүсвэр: Монголын хүн амын тоо. И.Майский,
“Орчин үеийн Монгол”. УБ. 2005. х.31


1911 оны хувьсгал- Диалектик

Цөөхөн хүн амтай монголчууд агуу их өвөг дээдэстэй улс байсан. Азид анхны их гүрнийг, Евро-Азийг эзэгнэсэн анхны их гүрнийг улмаар Дэлхийн Их Гүрнийг байгуулж байсан агуу их оюунлаг ард түмэн дахин тусгаар тогтнолоо тунхагласан явдал бол өвөг дээдэс, оюун ухаан оюун санаатай холбоотой байсан юм.




1911оны хувьсгал

1911 оны хувьсгалын дараа Монгол улсаа дэлхийн хөгжингүй улс орнуудтай мөр зэрэгцэн хөгжүүлэхийн тулд Монголын засгийн газар дэлхийн улс орнуудад парламентад ёс нэгэнт тогтсоныг хэлэлцэн үзэж Үндсэн хуульт засаглалыг тогтоож Улсын хурлыг байгуулах нь зүйтэй хэмээн үзэв.





1911-1914 онд Америк, Англи, Норвеги,
Япон, Орос, Франц, Герман, Швейцар,
Нидерланд улсын Үндсэн хуулиудыг орчуулж
бэлэн болгожээ.



Англи Улс, Харт хэмээх зарлиг бичиг




Норвеги, Хойд Америкийн Холбоот Улсын Үндсэн хууль



Хойд Америк, Япон (1889 он)



Японы Үндсэн Хууль 1889







Олон улсын Үндсэн хуулиудыг нэг бүрчлэн нягтлан судлаж, хооронд нь харьцуулж нэгтгэн дүгнэж “Олон улсын Үндсэн хуулийн оршил” гэсэн баримт бичгийг боловсруулсан байна. Уг баримт бичигт:

“... Англи улс болбоос бусад олон улсаас ялгардаг өөр бөгөөд хэдэн зуун онд анхан улс байгуулахаас эхэлж тогтсоор ирсэн хуучин заншил суртлыг үндэс болгож энэхүү хэмжээт засгийн Үндсэн хууль юугаан сахин хамгаалж, цагийг дагаж, тухайд залруулан дэлгэрүүлсээр иржээ. Бусад улсад ийм суртал байхгүй” (Олон улсын Үндсэн хуулийн оршил. УБ. 2009. х 7)

“Олон Улсын Үндсэн Хуулийн Оршил” баримт бичиг





... АРД АМЬТНЫ БОЛОВСРОЛ, БАЯН, ХООСОН СЭЛТ
АДИЛГҮЙ УЧИР ... ОЛОН ЗЭРЭГ ДЭВИЙН ЭРХ
МЭДЛИЙН ЗАХИРГАА ОЛГОСОН НЬ МАШ
ГАЙХАМШИГ МЭРГЭН ЗАСГИЙН БОДЛОГО ...”
ХЭМЭЭН АНГЛИ УЛСЫН ХЭМЖЭЭТ ЦААЗАТ
ЗАСАГЛАЛЫГ ТАЛАРХАН ТЭМДЭГЛЭСЭН БАЙДАГ.


ОЛОН УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ОРШИЛ. УБ. 2009. Х.14

Англи улс лугаа хөгжүүлэх бодлого

Англи улс нь анх 1215 онд Английн ван Иоанны тунхагласан “Их Харт” (The Great Charter)-ыг Үндсэн хуулийнхаа эх болгосон байдаг. Энэ олон зуун жилийн түүхтэй, олон зуунаар шалгагдан гарч ирсэн эрхийн бичгийг Богд хаант засгийн газар анхааралдаа авч **Англи улсын Үндсэн хууль бол хөгжингүй бусад олон орны Үндсэн хуулийн эх мөн гэдгийг**

“Олон улсын Үндсэн хуулийн оршил” баримт бичигт тодорхой заасан байдаг.

(Олон улсын Үндсэн хуулийн оршил. УБ. 2009. х.12)




“Олон улсын Үндсэн хуулийн оршил” баримт бичигт улс орон бүр Үндсэн хуулийнхаа дагуу янз янзын засаглалыг тогтоосон тухай тэмдэглэн үлдээсэн байна.

Уг баримт бичигт Америк, Англи, Итали, Швейцари, Нидерланд, Дани, Герман, Австри, Венгер, Япон, Португали, Испани, Румын, Орос улс Үндсэн хуулиа хэрхэн батлаж байсныг тэмдэглэжээ.

Англи улсын Үндсэн хууль лугаа Үндсэн хуулийг Монголд боловсруулах, хэмжээт цаазат засаглалыг тогтооход “Олон улсын Үндсэн хуулийн оршил” баримт бичгийн гол утга санаа нь чиглэгджээ гэж үзмээр байдаг.




1914 онд Үндсэн хууль боловсруулах бэлтгэл ажил дуусч Монгол улсын Үндсэн хуулийн эх сурвалж “Улсын эрх” баримт бичиг бэлэн болов.




Улсын Эрх, Улсын хэвлэлийн газар, 1924

“Улсын эрх” Үндсэн Хуулийн төслөөр бол хэмжээт эрхт хаантай, дээд доод танхим бүхий парламентат засаглалыг тогтоох эрх зүйн орчин бүрджээ.

1914 онд Богд хаан болон Засгийн газарт зөвлөх эрх бүхий Дээд Доод хурал байгуулагдав.





Монгол улсад хөрөнгтөний парламентат
засаглал буюу ардчиллын эхлэл тавигдажээ.



Өнөөдрийн лекцээрээ бид

монголчууд дэлхийн хэмжээнд хэрхэн сэтгэж улс орноо ардчиллын замаар хөгжүүлэх бодлого барьж байсан тухай болон

XIX зууны сүүл үеийн дэлхийн улс гүрнүүдийн Үндсэн Хуулийн түүх, субстанцыг мэдэж авлаа.



References

1. Олон улсын Үндсэн хуулийн оршил, ХЗҮХ хэвлэх үйлдвэр, 2009
2. Философия истории, Гегель Г.В.Ф, Санкт-Петербург, “Наука”, 1993
3. Түүвэр зохиолууд, Цэвээн Ж, Тана хэвлэх үйлдвэр, 1997



Анхаарал тавьсанд баярлалаа